



Хэвлэлийн мэдээ
2017 оны 5-р сарын 3

Холбоо барих:
+976 9710-9009

АмЧам Монгол АНУ-Монгол улсын худалдааны харилцааны товч хөтөч” баримт бичгийг боловсруулан гаргалаа

УЛААНБААТАР, Монгол улс - Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (АмЧам Монгол) нь АНУ-Монгол улсын хооронд худалдаа, бизнесийн харилцааг эрчимжүүлэх зорилгын хүрээнд “АНУ-Монгол улсын худалдааны харилцааны товч хөтөч” баримт бичгийг боловсруулан гаргалаа. Тус баримт бичиг нь хоёр улсын хооронд худалдаа, бизнесийн харилцааны ерөнхий мэдээлэл, бодлогын онцлох асуудлууд, болон АНУ-д бизнес хэрхэн эрхлэх болон шаардлагатай мэдээллүүдийг олж болох эх сурвалжуудыг агуулснаараа АНУ-д бизнес эрхлэх сонирхолтой компаниудад хөтөч болох зорилготой юм. Тус бичиг баримт нь зөвхөн ерөнхий хөтөч бөгөөд дэлгэрэнгүй, иж бүрэн зааварчилгаа биш юм.

2017 онд АмЧам Монгол нь “Өсөлтөд хүрэх арга зам 2017” баримт бичигтээ тусгагдсан стратегийн гол дөрвөн чиглэлд анхаарлаа хандуулан ажиллах ба үүнд гишүүн байгууллагуудад таатай нөхцөлтэй санхүүжилтийн эх үүсвэрийг эрэлхийлэх, хөдөө аж ахуй болон сэргээгдэх эрчим хүчний салбарын хөгжлийг дэмжих замаар эдийн засгийн төрөлжилтийг эрчимжүүлэх, сайтар төлөвлөсөн, тууштай, ил тод, тодорхой эрх зүй, зохицуулалтын орчинг бүрдүүлэх болон гишүүн байгууллагуудын амжилтын түүхийг сурталчилах замаар хөрөнгө оруулалтыг татах зэрэг чиглэлүүд багтаж байна.

Монгол Улсад хөрөнгө оруулалт татах болон АНУ-Монгол улсын худалдаа, бизнесийн харилцааг эрчимжүүлэх хүрээнд авч хэрэгжүүлж буй олон тооны ажлын хүрээнд АмЧам Монгол 2017 оны 6-р сард АНУ-аас Монгол улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт элчин сайд хатагтай Женифер Зимдал Галтаар удирдуулсан АНУ-руу хийх бизнесийн айлчлалыг зохион байгуулахаар ажиллаж байна. Энэхүү айлчлалд Монгол улсын Гадаад харилцааны сайд ноён Ц. Мөнх-Оргил оролцоно.

АмЧам Монголын тухай

АмЧам Монгол нь АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол нь 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны салбарын статустай. Мөн АмЧам Монгол нь Ази Номхон далайн 29 орнуудын Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.